



ТАВАНТОЛГОЙ ХК

ӨМНӨГОВЬ АЙМАГ

“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИ

Өмнөговь, Цогтцэций сум, Утас: 7535-5555, 9500-1619
и-мэйл: info@tavantolgoi.mn

2024.05.09 № 1-473
танай _____-ны № _____-т

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

“Талын цэнгэг трейд” ХХК-иас ирүүлсэн 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 24/075, 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 24/079 тоот албан бичгүүдтэй танилцаад дараах хариуг хүргүүлж байна.

Манай компаниас 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр зарласан “Нүүрс ачилт буулгалтын талбайн үйлчилгээ авах /багцтай/” ТТХК/20240103013 дугаар бүхий тендерийн баримт бичгээс доорх асуултад тодруулга хүссэн байна.

13. “Нэг компани хэд хэдэн багцад оролцох боломжтой эсэх”

- Нэг компани нэг л багцад орох боломжтой болно. 1-ээс дээш нүүрс ачилт буулгалтын талбайтай, техник болон хүний нөөц хангагдсан бол 1-ээс дээш багцад орж болно.

14. “Пүүний оператор албан хаагч нь пүүний засварын ажилтан эсвэл пүүний бүртгэлийн ажилтны аль нь болохыг тодруулах хүсэлтэй байна.”

- Тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1-д заасны дагуу пүүний оператор албан хаагч нь Стандарт хэмжил зүйн газрын мэргэжлийн сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.

15. “Пүүний оператор нь Гаалийн коллежийн пүүлэгчийн сургалтад сурсан байж болох уу”

- Тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1-д заасны дагуу пүүний оператор албан хаагч нь Стандарт хэмжил зүйн газрын мэргэжлийн сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.

16. “Хүний нөөцийн хүчин чадавх дээр пүүний оператор нь Стандарт хэмжил зүйн газрын мэргэжлийн сургалтын сертификаттай байх гэсэн боловч Стандарт хэмжил зүйн газраас сургалт тодруулан асуухад Пүүний оператор зориулсан биш ерөнхий хэмжилзүйн сургалт байдаг гэсэн. Энэ тал дээр дэлгэрэнгүй тайлбар өгнө үү.”

- Пүүний оператор албан хаагч нь Стандарт хэмжил зүйн газрын ерөнхий хэмжилзүйн сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байхад болно.

17. “Техникийн хүчин чадлын тендерийн шаардлага нь

Тоног төхөөрөмж	Багтаамж	Тоо хэмжээ
Утгуурт ачигч	3м ³	3 ширхэг ба түүнээс дээш
Утгуурт ачигч	5м ³	2 ширхэг ба түүнээс дээш
Утгуурт ачигч	7,8м ³	1 ба түүнээс дээш

Нийт шанагны багтаамж ойролцоогоор 27 м³ байна.

Манай компанийн нийт техникийн хүчин чадал 96 м³ үүнд:

Тоног төхөөрөмж	Багтаамж	Тоо хэмжээ
Утгуурт ачигч	4 хүртэл м ³	14ш
Утгуурт ачигч	4.5м ³	10
Утгуурт ачигч	5,4м ³	1

Нийлбэр шанагны багтаамжаар шаардлага хангана гэж үзэх үү? “

- Нийлбэр шанагны багтаамжаар тус шаардлагыг хангахгүй бөгөөд тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д зааснаар ирүүлэх шаардлагатай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ч.ГҮНЖДАГВА